



**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2017 оны 09 сарын 04 өдөр

Дугаар 88

Есөнбулаг сум

Болзол батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, Улсын Их Хурлын 2010 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн 3.2.1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Тэмээн сүрэг өсгөж, ашиг шимийг нэмэгдүүлэх уралдааны болзлыг 1 дүгээр хавсралтаар, тэмээчний анкетыг 2 дугаар хавсралтаар, шалгаруулах ажлын үзүүлэлтийг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Болзлыг дүгнэж шалгаруулахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн төсөвт тусгаж хэрэгжилтийг зохион байгуулахыг аймгийн Засаг дарга /С.Гансэлэм/-д даалгасугай.

3. Болзлыг сурталчилж, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг аймгийн Засаг дарга /С.Гансэлэм/, Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга /Б.Баян-Эрдэнэ/, сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Т.ТАНЗОРИГ

97

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Тэргүүлэгчдийн хуралдааны 2017 оны...⁰⁹
дүгээр сарын...-ний өдрийн...⁸⁸-р
тогтоолын...⁰¹-р хавсралт

ТЭМЭЭ УРАЛДААНЫ ӨСГӨХ БОЛЗОЛ

Нэг. Үндэслэл

Говь-Алтай аймгийн тэмээн сүрэг 1977 онд хамгийн олон буюу 55.5 мянган толгой байсан бол 2002 онд 22.3 мянган толгой болон буурч хорогдсон энэ үед аймгийн Засаг даргын 2004 оны 83 дугаар захирамжаар тэмээ өсгөх болзол зарлан хэрэгжүүлснээр 2016 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр 38.5 мянган толгойд хүрч 72.6 хувиар өссөн үр дүн гарсан байна.

Мөн тэмээн сүргийн тоо толгой өссөний зэрэгцээ үүлдэрлэг байдалд ихээхэн өөрчлөлт гарч Төхөм Тунгалагийн хүрэн тэмээ үүлдрээр батлагдсан.

Цаашид тэмээ өсгөх болзлыг улам боловсронгуй болгож тэмээн сүргийн тоо толгойг өсгөх, Төхөм Тунгалагийн хүрэн тэмээний удмын санг бататган хамгаалж нийт сүргийн үүлдэрлэг чанарыг сайжруулахаар тэмээ өсгөх болзлыг шинэчлэн боловсрууллаа.

Хоёр. Зорилго

2.1. Тэмээн сүргийн тоо толгойг өсгөж, үүлдэрлэг байдал, ашиг шимийг нэмэгдүүлэх, тэмээ маллах, эдлэх, уламжлалт өв соёл, арга технологийг хадгалан өвлүүлэхэд идэвх санаачлага гарган ажиллаж байгаа малчдыг дэмжиж урамшуулахад уралдааны зорилго оршино.

Гурав. Шалгуур үзүүлэлт

3.1. Тодорхойлогдож байгаа тэмээчин дараах нийтлэг шалгуур үзүүлэлтийг хангасан байна.

3.1.1. Тэмээн сүргээ сүүлийн 2 жил дараалан өсгөж, зүй бус хорогдол гаргаагүй байх.

3.1.2. Ингээ хээлтүүлэгт бүрэн хамруулж, ээлжийн ингэнээс 80-аас доошгүй хувиар ботго бойжуулсан байх.

3.1.3. Байгаль, цаг уур, орон нутгийн онцлогт тохирсон үүлдэр, омгийн үржлийн шилмэл хээлтэгч, хээлтүүлэгчээр сүргийнхээ чанарыг сайруулж, ашиг шимийг нэмэгдүүлсэн байх.

3.1.4. Улс, бүс, аймаг, сумын үзэсгэлэн худалдаа, их говийн тэмээний баярт идэвхтэй оролцдог байх.

3.1.5. Цөөн тэмээтэй 2-оос доошгүй малчин өрхийн амьжиргааны түвшинг сайжруулахад 2-оос цөөнгүй үржлийн тэмээгээр дэмжлэг үзүүлсэн байх.

3.1.6. Нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд хамрагдаж, шимтгэл төлсөн байх.

3.1.7. Малын индексжүүлсэн даатгалд нийт тэмээн сүргийнхээ 10-аас доошгүй хувийг хамруулсан байх.

3.1.8. Малын хулгайн гэмт хэрэгт холбогдоогүй байх.

Дөрөв. Материал бүрдүүлэх

4.1. Тэмээчинг тодорхойлохдоо багийн Иргэдийн нийтийн хурлын шийдвэрийг үндэслэн сумын аварга малчин болсон, болзлын шалгуур үзүүлэлтийг хангасан малчдыг сумын Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэн нэг тэмээчинг шалгаруулж, хүсэлтийн хамт аймгийн хөдөө аж ахуйн асуудал хариуцсан байгууллагад жил бүрийн 01 дүгээр сарын 05-ны дотор ирүүлсэн байна.

4.2. Тэмээчинг тодорхойлохдоо дараах материалыг бүрдүүлнэ.

4.2.1. Тэмээчний товч анкет /Хавсралт 2/

4.2.2. Тэмээчний ажлын үзүүлэлт /Хавсралт 3/

4.2.3. Тэмээчний ажил байдлын тодорхойлолт

4.2.4. Багийн иргэдийн Нийтийн Хурлын тогтоол, тэмдэглэл

4.2.5. Сумын Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэр

4.2.6. Холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, иргэний гаргасан баталгаа

4.2.7. Тэмээчний ажлыг газар дээр нь шалгасан сумын Засаг даргын тамгын газрын дүгнэлт, фото зураг.

4.3. Тодорхойлолтод энэ болзлын 3, 4-т заасан шалгуур үзүүлэлт, материалыг дараах байгууллага, албан тушаалтан баталгаажуулж, баримтаар нотолсон байна.

4.3.1. Багийн Иргэдийн нийтийн хурлын дарга 4.2.4;

4.3.2. Сумын Засаг даргын Тамгын газар 4.2.1, 4.2.2, 4.2.3, 4.2.5, 4.2.7;

4.3.3. Сумын нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын улсын байцаагч 3.1.6;

4.3.4. Тухайн даатгалын байгууллага 3.1.7;

4.3.5. Цагдаагийн хэсгийн төлөөлөгч 3.1.8;

Тав. Уралдааныг дүгнэх

5.1. Аймгийн хөдөө аж ахуйн асуудал хариуцсан байгууллага сумдаас ирсэн тэмээчдийн материалыг нэг бүрчлэн хянаж энэхүү болзлын шалгуур үзүүлэлтийг хангасан материалыг ажлын үзүүлэлтээр нь эрэмбэлэн 14 хоногт багтаан аймгийн Засаг даргын зөвлөлөөр хэлэлцүүлэн, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанд оруулж шийдвэрлүүлнэ.

5.2. Тэмээ өсгөх уралдааны болзлыг хамгийн сайн хангасан 1 тэмээчинг шалгаруулж “Аймгийн аварга малчин” цол /үнэмлэх, энгэрийн тэмдэг/ олгож шагнаана.

Зургаа. Шагнал олгох

6.1. Шагналыг билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн нэгний өмнө гардуулна.

99.


Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Тэргүүлэгчдийн хуралдааны 2017 оны...⁰⁹
дүгээр сарын ...⁰⁴...-ний өдрийн...⁸⁸-р
трөгтоолын...⁸⁸-р хавсралт

ТЭМЭЭЧНИЙ ТОВЧ АНКЕТ

Зураг

1	Аймаг, сум, багийн нэр	
2	Ургийн овог	
3	Эцэг /эх/-ийн нэр	
4	Нэр	
5	Төрсөн он, нас, хүйс	
6	Боловсрол	
7	Ам бүлийн гишүүдийн тоо, тэдний эрхэлж байгаа ажил	
8	Улсад ажилласан хугацаа, хийж байсан ажил	
9	Малчнаар ажилласан хугацаа	
10	Төр, засгаас авсан шагнал, огноо	

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Тэргүүлэгчдийн хуралдааны 2017 оны 09
дүгээр сарын 04-ний өдрийн 88-р
тогтоолын 03-р хавсралт



ТЭМЭЭЧИН ШАЛГАРУУЛАХ АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

№	Үзүүлэлтийн нэр	... он	... он	... он
1.	Оны эхний тэмээний тоо			
2.	Нийт ингэний тоо			
3.	Ингэний эзлэх хувь			
4.	Буурны тоо			
	Үүнээс худалдан авсан буурны тоо			
5.	Оны эхний ээлжийн ингэнээс бойжуулсан ботго			
6.	Малжуулахад өгсөн тэмээний тоо			
7.	Зүй бусаар хорогдсон тэмээ			
8.	Малын индексжүүлсэн даатгал /мян.төг/			
9.	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл /мян.төг/			
10.	Нийгмийн даатгалын шимтгэл /мян.төг/			
11.	Тэмээтэй холбоотой баяр, үзэсгэлэн худалдаанд оролцсон байдал			